



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 09 сарын 22 өдөр

Дугаар A/119

Улаан-Уул

Түүх соёлын үл хөдлөх дурсгалийн
үзлэг тооллогыг зохион
байгуулах тухай

Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 13 ны өдрийн А/587 тоот захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын нутаг дэвсгэрийн түүх соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг тооллогыг зохион байгуулах ажлыг 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрөөс 10 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулсугай.

2. Сумын нутаг дэвсгэрийн түүх соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг тооллогыг зохион байгуулах ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Энхтайван (Соёлын төвийн дарга)

Гишүүдэд: Т.Сэвжиддулам (Газрын даамал)

Ж.Машбат (Байгаль хамгаалагч)

С.Жаргалсайхан (ЕБС-ын багш)

Нарийн бичгийн дарга: Ж.Дондол (Соёлын төвийн өвийн ажилтан)

3. Сумын хэмжээнд байгаа түүх соёлын үл хөдлөх дурсгалуудын тооллогыг чанартай зохион байгуулж, түүх соёлын үл хөдлөх дурсгалт газруудын дэлгэрэнгүй тайлбарыг тус бүр гарган сумын аялал жуулчлалын нэгдсэн маршрутад оруулах саналыг төлөвлөсөн, зурагжуулсан тайланг ирүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Д.Энхтайван)-д даалгасугай.

ДАРГА Т.ЭРДЭНЭБАТ



642201241